

## ТАНИЛЦУУЛГА

*Журам шинэчлэн батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай*

2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны шимтгэл төлөх журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан.

Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 212 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ыг батлан одоог хүртэл мөрдөж байна.

Ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө хариуцан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нийт хугацаа дээр энэ журмаар зохицуулсан нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааг нэмж, даатгуулагчид нийгмийн даатгалын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж тогтооход энэхүү журмыг баримтлана.

Энэхүү журамд нийтдээ 4 удаа, үүнээс 1996 онд нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ нь цэргийн албанаас халагдаж буй байлдагч, түрүүчид нийгмийн даатгалын дэвтэр нээн /хуучин дэвтэртэй бол түүн дээр нь/ бичилт хийж төлсөн шимтгэлийн хэмжээг баталгаажуулах; 2008 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан иргэний алба хааж байсан цэргийн анги, байгууллага татан буугдсан бол түүнд олгох тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувь хэмжээгээр тооцон улсын төсвөөс нийгмийн даатгалын санд шилжүүлэх; 2015 онд цаа буга маллан тайгад амьдарч байгаа хөдөлмөрийн насны, өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй цаатан иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг төр хариуцан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын санд улсын төсвөөс төлөх; 2019 онд сайн дураар даатгуулагч эх хүүхдээ 3 нас хүртэл асрах хугацааны шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс төлөх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогод ногдох шимтгэлийг даатгуулагч өөрөө хариуцах зэрэг нэмэлт, өөрчлөлт орсон болно.

Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааг зохицуулсан харилцааг Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулиар зохицуулж байгаагаас гадна Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Гаалийн тухай, Монгол Улсын Хилийн тухай, Цагдаагийн албаны тухай, Дипломат албаны тухай зэрэг хуулиар зохицуулсан байна.

Түүнчлэн Нийгмийн даатгалын тухай хуульд 2019 онд даатгуулагч эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн тоогоор нэмэгдүүлэн тооцох талаар нэмэлт орсон.

Эдгээр нөхцөл байдлыг үндэслэн “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулав.

Журам шинэчлэгдсэнээр даатгуулагчийн ажил олгогчоос болон өөрөө хариуцан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд нэмэгдэх нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааны шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч, төр, нийгмийн даатгалын сангаас хэрхэн төлөх, бүртгэх, тайлагнах харилцаа тодорхой болж, холбогдох хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтүүд болон нийгмийн даатгалаас бусад дээр дурдсан хуулиудын холбогдох зохицуулалт нэг мөр хэрэгжих боломж бүрдэнэ.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ